



**“УЛААНБААТАР ТЕАТР” ОНӨТҮГ
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ
ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2025**

УЛААНБААТАР ТЕАТР ОНӨТҮГ-ЫН 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 03.

лаанбаатар хот

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1. Үндэсний эв нэгдэл, Монгол өв соёлыг сурталчилсан соёлын олон талт ажил зохион байгуулна.

Гүйцэтгэлийн зорилт 1.1. “Хархорум” үндэсний агуулга шингэсэн шинэ уран бүтээлийг үзэгчдийн хүртээл болгоно.

Хүрэх түвшин. Уран бүтээлийн тоо -1

Биелэлт: “Хархорум” үндэсний агуулга шингэсэн шинэ уран бүтээлийн зохиолыг бичиж батлуулсан. Тус зохиол дээр үндэслэн хөгжмийн найруулгыг хөгжмийн зохиолч Ш.Сугарцэрэн хийж, ерөнхий продюсероор Э.Цэнд-Аюуш, зохиолчоор яруу найрагч П.Нямлхагва, ерөнхий найруулагчаар МУУГЗ Б.Ганболд, хөгжмийн зохиолчоор МУУГЗ Б.Алтанхуяг, бүжиг дэглээчээр МУУГЗ Д.Баярбаатар нар ажиллахаар төслийн багийг бүрдүүлсэн боловч 2025 оны төсөвт суулгасан уран бүтээлийн санхүүжилт хэмнэлтийн тухай хуулиар эргүүлэн татагдсан тул нийслэлийн 2026 оны төсөвт уран бүтээлийн зардлыг багтаан шийдвэрлэж өгсөн. Хэрэгжилт 30%

Гүйцэтгэлийн зорилт 1.2. Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль, “Даншиг наадам -Хүрээ цам” соёлын өвийн наадмын соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.

Хүрэх түвшин. Ажлын тоо -1

Биелэлт: Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр “Хүрээ цам-Даншиг наадам 2025” шашин, соёлын наадам зургаадугаар сарын 28-29-ний өдрүүдэд Хүй долоон худагт болсон. Энэ үеэр жуулчид болон иргэдэд зориулсан олон арга хэмжээ зохион байгуулагдаж хүчит бөхийн барилдаан, хурдан морь болон жороо морины уралдаан, шагай, сур харвааны наадам, сээр цохих тэмцээн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үзэсгэлэн, монгол хувцасны үзүүлбэр, есөн дүүргийн Ардын авьяаснуудын тоглолт зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд Улаанбаатар театрын Хангарди оркестр болон дуу анги, бүжиг анги, Анир поп оркестр бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож нийт 150 гаруй уран бүтээлч оролцсон.

Уг арга хэмжээнд Төрийн шагналт Б.Шаравын хөгжим “Сэрсэн тал” аялгууг Хангарди оркестр тоглож, Монгол ардын уртын дуу “Дөрвөн цаг”-г Улаанбаатар театрын найрал дуучид дуулж, бүжигчид “Хүндэтгэлийн бүжиг”, “Уран сугсраа” зэрэг бүжгээр оролцсон. Соёлын Яам, НЗДТГ болон НАЖГ-тай хамтран зохион байгуулсан.

“Нүүдэлчин” соёлын фестиваль 2025 оны 08 дугаар сарын 16-18-ны өдрийн хооронд Налайх дүүрэгт болж уг арга хэмжээнд Нийслэлийн Улаанбаатар театрын 13 бүжигчин Үндэсний Урлагийн Их театрын бүжигчидтэй хамтран бүжиглэж 6000 гаруй үзэгчдэд үйлчилсэн байна. Хэрэгжилт 100%





ХОЁР. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

2. Нийслэлийн нутаг дэвсгэрт байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг хамгаалалтад авч сэргээн засварлана. /НХТЖҮЧ-1.1.2; НХТ-2.6.16/

Гүйцэтгэлийн зорилт 2.1 Театрын тайзны гэрэлтүүлэг, дуу шумны тоног төхөөрөмжийг шинэчлэх ажилд оролцож, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хүрэх түвшин: Багц ажлын тоо -1

Биелэлт: Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор театрын тайзны гэрэлтүүлэг, дуу шумны тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр тендер зарласан. (Улаанбаатар хот) НХААГ (20250102023) дугаар бүхий тус тендерт “Электрон Техник” ХХК шалгарч “Улаанбаатар театр”-т шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх №ОН251201555 тоот гэрээний гүйцэтгэлийн дагуу “Электрон техник” ХХК нь тайзны гэрэлтүүлгийн 16 нэр төрлийн 141 ширхэг, дуу шумын 20 нэр төрлийн 103 ширхэг 399,815,000 (гурван зуун ерэн есөн мянга найман зуун арван таван мянга)-н төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн №01 дугаар “Тоног төхөөрөмж хүлээлцсэн акт” үйлдэн хүлээн авч 100 хувь ашиглалтад оруулсан. Театрын талаас Захиргааны ахлах мэргэжилтэн Б.Түмэндэлгэр, Тайз үйлдвэрлэлийн ангийн дарга Ц.Батцэнгэл нар хариуцан ажилласан. Хэрэгжилт 100%






ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:


3.Үндэсний агуулга бүхий соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ. /НЗДҮАХ-2.4.3 ; НЗДҮАХ-2.4.6 ; НХТ-2.6.2; НХТ-3.4.1/

Хүрэх түвшин: Багц ажлын тоо -1

Гүйцэтгэлийн зорилт 3.1 Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар театрын байрыг засварлах ажилд бүтээлчээр оролцож, үйлчлүүлэгчийн тав тухтай орчин бүрдүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 3,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Улаанбаатар театрын их засварын ажил 95 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байгаа ба 2025 оны 12 сарын 01-ний өдөр дуусгаж, Улсын комисст хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна. Дээвэр, гадна фасад, үзэгчдийн заалны акустик хавтан, дроз шал, үзэгчдийн сандал, хөгжимчдийн ям, тайзны хулдаас, 4 давхрын бүжигчдийн бэлтгэлийн заал, үзэгчдийн эр, эм, тусгай хэрэгцээт иргэдийн ариун цэврийн өрөө, 2 давхрын үзэгчдийн хүлээлгийн танхим-фоей, 2 давхрын хөгжимчдийн өрөө, оффисын өрөөнүүд, салхивчны халуун усаар тэжээх хоолойг бүрэн шинэчилсэн, тайзны гал унтраах спринклер, 1 давхрын үзэгчид орох хэсгийн бүрэн засвар гэх мэт ажлууд 100 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн ба одоогийн байдлаар 1 давхрын жүжигчдийн өрөөнүүдэд засвар хийгдэж дуусах шатандаа ороод байна. Ингэснээр театраар үйлчлүүлэх иргэд, үзэгч олны тав тухтай, тохилог орчин бүрдээд байна. Хэрэгжилт 95%





Гүйцэтгэлийн зорилт 3.2 Дэлхийн Бүтээлч хотуудын сүлжээнд элссэнтэй холбогдуулан байгууллагын онцлогт тохирсон ардын урлаг, уран нугаралтын фестивалийг зохион байгуулна.

Хүрэх түвшин: Зохион байгуулсан ажлын тоо -1



Биелэлт: “Уян” уран нугаралтын олон улсын фестивалийг санхүүжилтийн асуудлаас шалтгаалан “Улаанбаатар цирк” ХХК-тай хамтран 2025 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, дэлхийд уран нугаралтаараа гайхагдсан Европ, Азийн улс орнуудын мэргэжлийн 100 гаруй уран нугараачид, циркийн жүжигчид оролцож, өөрсдийн өвөрмөц үзүүлбэрээс бүрдсэн хамтарсан тоглолтыг нийслэлийн иргэдэд хүргэсэн. Тус фестивалийг 2000 гаруй иргэд, жуулчид үзэж сонирхож, цахимаар 10 гаруй рийлс, фото, видео контентуудыг нийтлэн 98,800 хандалт авсан байна. Хэрэгжилт 100%



Гүйцэтгэлийн зорилт 3.3 Алслагдсан нутгийн иргэдэд нийслэлийн театрын уран бүтээлийг таниулан сурталчлах тоглолтуудыг зохион байгуулна.

Хүрэх түвшин: Тоглолтын тоо -15

Биелэлт: Багахангай дүүрэгт бүрэн бүрэлдэхүүнээр очиж тоглолт хийсний дээр эдгээр арга хэмжээнд дүүргийн ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг түлхүү хамруулан үйлчиллээ. Улаанбаатар театрын гоцлол дуучин Т.Баянжаргал, О.Анхчимэг нарын “Хүрээ хөг” тоглолтыг 05 дугаар сарын 27-ний өдөр Баянхонгор аймгийн иргэдэд хүргэх ажлыг амжилттай зохион байгуулсан. Энэхүү тоглолтод 400 гаруй үзэгчдэд хүрч үйлчилсэн байна. Улирлын байдлаас шалтгаалан тоглолт арга хэмжээний дийлэнх хэсэг нь нийслэлийн үзэгчдийг хамардаг бөгөөд сүүлийн саруудад хөдөө орон нутагт болон нийслэлийн алслагдсан дүүргүүдэд хүрч үйлчлэхээр төлөвлөн ажилладаг. Хэнтий аймгийн Цэнхэр мандал сумын 100 жилийн наадмын нээлт, хаалтын арга хэмжээнд уран бүтээлчид оролцсон. Хэрэгжилт 30%



Гүйцэтгэлийн зорилт 3.4 Жуулчдад зориулсан “Морьтны шоу” үзүүлбэрт үндэсний өв соёлоо сурталчилсан тоглолт зохион байгуулна.

Хүрэх түвшин. Хамтран хүрээ үзэгчдийн тоо 3000


Биелэлт: Жуулчдад зориулсан шинэ бүтээгдэхүүн зохион байгуулах ажлын хүрээнд Хүй 7 худагт байрлах Бөмбөрцөг театрт жуулчдад зориулсан “Морьт цирк болон Ардын урлагийн тоглолт”-ыг зохион байгуулахаар бэлтгэл ажлаа ханган, морьд болон жүжигчид бэлтгэлээ ханган ажилласан. 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн уг ажлын санхүүжилт татагдсан шалтгаанаар хэрэгжээгүй ч уран бүтээлийн хувьд жүжигчдийн бүрэлдэхүүн, тоглолтын хөтөлбөр батлагдаж бэлтгэл ажил бүрэн хангагдсан. Санхүүжилт нь тус тоглолтын тайз декораци, маркетинг, хувцас, жижиг хэрэглэлд зарцуулагдахаар төсөвлөгдсөн. Хэрэгжилт 30%

Гүйцэтгэлийн зорилт 3.5 Хүүхдэд зориулсан уран бүтээл, төсөл арга хэмжээнд дэмжлэг үзүүлж ажиллана.

Хүрэх түвшин: Дэмжлэг үзүүлсэн ажлын тоо -6

Биелэлт: Тайлант хугацаанд хамтын ажиллагааны гэрээний дагуу бүтээсэн “Намайг дурсаарай Коко” хүүхдийн жүжгийг 2025 оны 10 дугаар сарын 25, 11 сарын 01, 02, 16-ны өдрүүдэд Улаанбаатар театрын тайзнаа нийт 12 удаагийн тоглолт зохион байгуулж нийт 3136 гаруй хүүхдүүдэд хүрч ажилласан байна. Мөн “Зөрүүд Гринч” хүүхдийн жүжгийг 12 дугаар сарын 13, 14, 20, 21 өдөрт 3 удаа, нийт 12 удаагийн тоглолт хийхээр төлөвлөөд

байна. Улаанбаатар театрын тайзны засварын ажил бүрэн гүйцэт дуусаагүй байгаа тул “Цаст Сарьдагийн Олмасс” хүүхдийн жүжиг 2026 оны 2 сард нээлтээ хийхээр болсон. Эдгээр хүүхдийн жүжгийг Маппет хүүхэлдэйн театр ХХК-тай хамтран зохион байгуулж ажилласан. Маппет хүүхэлдэйн театрт хамтран “Том чихт Дамбо”, “Намайг дурсаарай Коко”, “Зөрүүд Гринч”, “Цаст сарьдагийн Олмасс” зураг хүүхдийн жүжгийн уран бүтээлд хамтран ажиллаад байна. Хэрэгжилт 100%



ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Гүйцэтгэлийн зорилт 4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Хүрэх түвшин: Мэдээллийн давтамж -12

Биелэлт: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох хууль, журмын дагуу 2025 оны батлагдсан төсөв, сарын төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ, төсөв хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгнөөс дээш гүйлгээний орлого, зарлагын мэдээлэл болон бусад холбогдох баримт мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд 171 мэдээллийг нээлттэй байршуулан ажилласан. Хэрэгжилт 100%

нийтэлсэн. Мөн театрын үндсэн уран бүтээлчдийн бие даасан тоглолтууд болох “DUO TENOR” оператик поп концерт, бүжиг ангийн шилдэг үзүүлбэрүүдээс бүрдсэн “CHILL DANCE NIGHT” тоглолт, Өвөл цагийн нээлтийн тоглолт “Хүрээ ба Классик - 2” зэрэг тоглолтуудын мэдээлэл, идэвхжүүлэлтийн рийл, бичлэг, шторк, постер зэрэг тогтмол цагийн үеийн мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор 206,000 хүний хандалт авч, хагас жилд дагагчдын тоог 3,900 - 5,600 болгож нэмэгдүүлсэн. Хэрэгжилт 100%



Гүйцэтгэлийн зорилт 4.4. Соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Хүрэх түвшин: Хамтын ажиллагааны тоо 6

Биелэлт: 2025 онд “Улаанбаатар театр” ОНӨТҮГ нь гадаад харилцааны хамтын ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүллээ. Гадаад тоглолтоор нийт 6 улс оронд 8 удаагийн тоглолт арга хэмжээнд очиж уран бүтээлээ өргөн барилаа.

- Бүгд Найрамдах Солонгос Улсад 2
- Япон улсад 1
- Бүгд Найрамдах Унгар Улсад 1
- Польш Улсад 1
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсад 2

Энэтхэг улс Банглор, Агро хотод тус тус 1 удаагийн тоглолт хийсэн.

1.2025 оны 04 дүгээр сарын 23-27-ний хооронд БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойн хүрээнд аялал жуулчлалын экспо арга хэмжээнд О.Оюунцэцэг /Дуучин/, Ч.Мэндсайхан /Бүжигчин/, Б.Бишрэлт-Азбаяр /Хөгжимчин/, Э.Намундарь /Хөгжимчин/, Б.Батзаяа /Хөгжимчин/ гэх 5 н уран бүтээлч оролцоод ирсэн.



2.Монгол улс, Унгар улс хооронд Дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойн хүрээнд Унгар улсын нийслэл Будапешт хотноо 2025 оны 05 дугаар сарын 10,11-ний өдөр “Улаанбаатарын соёлын өдрүүд” үйл ажиллагааны хүндэтгэлийн тоглолтод 64 уран бүтээлч оролцсон.





3. 2025 оны 05 дугаар сарын 23-25-нд БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулагдсан найрамдалт хотуудын Hi Seoul фестивальд Д.Мядагдам /дуучин/, Г.Амартүвшин /Хөгжимчин/, Г.Гантуяа /Хөгжимчин/, Ж.Буянтогтох /Дуучин/, П.Энхтогтох /Бүжигчин/, З.Энхжаргал /Бүжигчин/, У.Номин-Эрдэнэ /Хөгжимчин/, Д.Цэвэлсүрэн /Бүжигчин/, Б.Бат-Ундрах /Хөгжимчин/ нийт 9 уран бүтээлч амжилттай оролцсон.



4. 2025 оны 06 дугаар сард Солонгос улсын Сөүл хотод "40th Seoul International travel fair" үзэсгэлэн зохион байгуулагдаж орон орноос ирсэн 400 гаруй тур оператор компани оролцсон үзэсгэлэнд "Улаанбаатар театр"-ын уран бүтээлчид /гоцлол дуучин МУСТА О.Анхчимэг/ дөрвөн өдрийн турш 20 удаа богино хэмжээний үндэсний урлагийн тоглолт тоглосон бөгөөд манай улс "BEST BOOTH" шагнал хүртсэн.



5.2025 оны 06 дугаар сарын 03-09-ний өдрүүдэд Монгол Улс, БНПУ хооронд Дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ой, Монгол улсын орчин цагийн зэвсэгт хүчний ойн хүрээнд зохион байгуулагдаж буй хүндэтгэлийн “НААДАМ” хүлээн авалтад БНПУ дахь Монгол улсын элчин сайдын яамны нийт ажилчид болон тэдний урилгаар хүрэлцэн ирсэн БНПУ-ын ЕТГ-ын хүндэт зочид, БНПУ-ын Гадаад харилцааны болон Гадаад хэргийн яамны хүндэт зочид мөн Польш улсад суугаа элчин сайдын яамдын хүндэт зочдын төлөөлөл зэрэг нийт 100 гаруй хүмүүст Улаанбаатар театрын Д.Түвшинцогт /хормейстр/, Т.Баянжаргал /дуучин/, Г.Жаргалмаа /дуучин/, Т.Санжаажамц /морин хуурч, хөөмийч/, О.Ганзаяа /бүжигчин/, Г.Аззаяа /бүжигчин/, Ч.Мэндсайхан /бүжигчин/, Н.Өгөөдэй /бүжигчин/, С.Цэнддаваа /уран нугараач/ 9 уран бүтээлчид тоглолтоо толилуулсан.



6.10 сард БНСУ-ын Гванжу хотод “Дурсамж-2025” фестивалд гоцлол дуучин МУСТА А.Наранбаатар, МУСТА А.Отгонболд нар амжилттай оролцсон;

7.Кыргызийн Ерөнхийлөгчийн ивээл дор явагдсан «урлагаар дамжуулан ард түмнүүдийг нэгтгэж, энх тайван, нөхөрлөлийг дэмжих «Хил хязгаар үгүй хөгжим, соёл, нөхөрлөл» уриан дор явагдсан «МЕЙКИН АЗИЯ-2025» наадамд Улаанбаатар театрын гоцлол дуучин А.Наранбаатар, А.Отгонболд нар амжилттай оролцож ая, дуугаа өргөсөн.



8.2025 оны 11 дүгээр сарын 19-24-ний хооронд Энэтхэг улсын Банглор хотод "World Culture Festival" фестивалд дэлхийн 65 улсын 720 уран бүтээлч хөгжимчид оролцсон бөгөөд тус зохион байгуулагдсан арга хэмжээнд хөгжимчин Х.Бархүү Б.Мягмарцэрэн нар оролцоод ирсэн.

9.2025 оны 11 дүгээр сарын 24-30-ний хооронд Энэтхэг улсын Агра хотод зохион байгуулагдсан арга хэмжээнд дуучин Т.Баянжаргал, Хөгжимчин Г.Бат-Өлзий нар Монголын соёл, урлаг, морин хуур, уртын дуу, бий биелгээ орчин үеийн бүтээлүүдийг дэлхий дахины үзэгч түмэнд хүргээд ирсэн. Хэрэгжилт 100%



Гүйцэтгэлийн зорилт 4.5. Уран бүтээлчдийн уран бүтээл туурвих сэтгэлгээг дэмжиж, тэдний санаачлан зохион байгуулсан ажлыг бүх талаар дэмжиж ажиллана.

Хүрэх түвшин: Хамтын ажиллагааны тоо 6


Биелэлт: 2025 оны 04 дүгээр 04-ний өдөр Нийслэлийн Соёл, урлагийн газрын “АСА” аренад зохион байгуулсан СТА Гоцлол дуучин Т.Баянжаргал, Уртын дуучин О.Анхчимэг нарын хамтарсан “Хүрээ хөг” тоглолтыг 2500 гаруй үзэгчдийн хүртээл болгоход бүх талын дэмжлэг үзүүлж ажилласан.



Тус тоглолтод Улаанбаатар театрын уран бүтээлчид бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцсон. Мөн 2025 оны 04 дүгээр сарын 19,20-ны өдрүүдэд Монголын Урлагийн Зөвлөлөөс санаачлан зохион байгуулсан “Тойрог-Ариун хавар” олон улсын орчин үеийн бүжгийн тоглолтод бүжиг ангийн 6 уран бүтээлчид амжилттай оролцож, шинэлэг төрлийн уран бүтээлийг 800 гаруй үзэгчдийн хүртээл болгоход зохих хэмжээний дэмжлэг үзүүлж ажилласан.



2025 оны 10 дугаар сарын 16-ний өдөр Улаанбаатар театрын дуучин Соёлын тэргүүний ажилтан Г.Жаргалмаагийн “ЖАРГАЛМАА” нэртэй анхны бие даасан тоглолт Монгол бөхийн өргөөнд амжилттай болж үзэгчдийн хүртээл болсон.




2025 оны 11 дүгээр сарын 26, 27-ний өдрүүдэд театрын Гоцлол дуучин А.Наранбаатар, А.Отгонболд нарын санаачилсан “DUO TENOR” тоглолт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөсөн “DUE TENOR” оператик поп концертын гол онцлог нь: Дэлхийн сонгодог болон мюзикл бүтээлүүдийг поп оркестртой, Монголын сонгодог дуу болон романс хэлбэрийн

бүтээлүүдийг амьд хөгжимтэй хослуулсан цогц илэрхийллийг өөрсдийн дуулах ур чадварт тулгуурлан, орчин цагийн хөгжмийн найруулга, тайз дэлгэцийн шинэлэг шийдлээр үзэгчдийн хүртээл болсон.



2025 оны 12 дугаар сарын 5-6-ний өдрүүдэд бүжиг ангийн уран бүтээл болох "CHILL DANCE NIGHT" dance show Жазз хөгжмийн эгшигт сэтгэлээ жаргаах гайхалтай бүжгийн тоглолт тоглогдохоор бэлтгэл ажилдаа ороод байна.





2025 оны 12 дугаар сарын 12-нд “Монгол бахархал” уриатай “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд Нийслэлийн Улаанбаатар театрын уран бүтээлчид ардын урлаг, сонгодог урлаг болон орчин үеийн урлагийн сор болсон бүтээлүүдийг нэгэн тайзнаас хүргэх өвөл цагийн нээлтийн тоглолтоо үзэгч түмэнд хүргэхээр бэлтгэл ажилдаа орон ажиллаж байна.



Гүйцэтгэлийн зорилт 4.6. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллана.

Хүрэх түвшин: Хамтын ажиллагааны хэрэгжилтийн хувь 100%.

Биелэлт: 2025 онд цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 118, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 50, бичиг хэрэг, шуудан холбоо, тээвэр шатахуун, бусад хангамжийн материалын зардал 78, байр ашиглалттай холбоотой тогтмол

зардал 7, эд хогшил, урсгал засварын зардал 6, бараа үйлчилгээний бусад зардал 299, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 25 гүйлгээг тус тус батлагдсан төсвийн хөтөлбөр, арга хэмжээ, эдийн засгийн ангилаллын дагуу төсвийг үр дүнтэй зарцуулж өр, авлагагүй ажилласан. НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг 12 удаа хянуулж баталгаажуулсан. Хэрэгжилт 100%

Гүйцэтгэлийн зорилт 4.7. Театрын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, үйлчилгээний соёл, харилцааны соёл, эрүүл мэндийн талаар сургалтыг зохион байгуулна.

Хүрэх түвшин: Сургалтын тоо 6

Биелэлт: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд театрын Ёс зүйн дэд хорооны гишүүд хэрэгжилтэд өдөр тутам хяналт тавьж, албан хаагчдын ёс зүйн болон хариуцлагын чадамжийг нэмэгдүүлж байна. Албан хаагчдад театрын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журмын талаар 2 удаагийн сургалтыг Ёс зүйн дэд хорооноос төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажилласан. Мөн, 2025 оны 04-дүгээр сарын 24-нд уран бүтээлчид, албан хаагчдад “Монос групп”-тэй хамтран хүний эрдэс бодисын талаар зөвлөгөө, мэдээлэл оношилгоо хийж хамтран ажилласан уг арга хэмжээнд нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байранд байрлах нийслэлийн байгууллагуудын нийт 189 албан хаагч хамрагдсан. Үүнд “Хүний нөөцийн хөгжлийн төв”, “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар”-ын албан хаагчид оролцсон нь зохион байгуулсан ажлын хамрах хүрээг өргөтгөсөн ажил болж өнгөрсөн. 2025 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр Бие бялдрын хөгжил, тэсвэр хатуужлыг тодорхойлох сорил авч, Эрүүл мэнд, эрүүл амьдралын хэв маяг эмийн зохистой хэрэглээ, Артерийн даралтаа хянах сэдвүүдээр сургалтыг нийт албан хаагчдад зохион байгуулсан. Тус сургалтын үйл ажиллагаанд нийт 69 албан хаагч хамрагдсан. Хэрэгжилт 100%



Гүйцэтгэлийн зорилт 4.8. Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлнэ.

Хүрэх түвшин: Хамтын ажиллагааны хэрэгжилтийн хувь 100

Биелэлт: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар бүлгийн 5.1.1 арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын дотоод үнэлгээг зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу байгууллагын дотоод үнэлгээг ажлын хэсэг байгуулан, үнэлгээний цахим маягтыг ашиглан байгууллагын мэдээллийг, дотоод үнэлгээг үнэн зөв, бодит мэдээлэлд тулгуурлан, чанартай үр дүнтэй зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хэрэгжилт 50%

Гүйцэтгэлийн зорилт 4.9. MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны стандартын нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.

Хүрэх түвшин: Хамтын ажиллагааны хэрэгжилтийн хувь 100

Биелэлт: Улаанбаатар Театр нь 2025 оны 2 дугаар хагаст "MNS ISO 9001:2016" чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлэх зорилт дэвшүүлэн ажилласан ажлын хүрээнд "SFCS" ХХК-иар анхан шатны аудитын ажлыг хийлгээд байгаа бөгөөд хоёр дах шатны аудит хийлгэх, албан хаагчдад MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны сургалт явуулахаар хүсэлтээ илгээсэн. Хэрэгжилт 50%

Гүйцэтгэлийн зорилт 4.10. Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.

Хүрэх түвшин: Хамтын ажиллагааны хэрэгжилтийн хувь 100

Биелэлт: Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний №43 дугаартай тогтоолын хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", "Үнэлгээ хийх журам", "Хяналт-шинжилгээ хийх журам" гэсэн шинээр батлагдсан журмуудыг судалж хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 6 зорилтын хүрээнд 46 арга хэмжээнд үнэлгээ хийж ажилласан. Хэрэгжилт 50%

Гүйцэтгэлийн зорилт 4.11. Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

Хүрэх түвшин: Хамтын ажиллагааны хэрэгжилтийн хувь 100

Биелэлт: Хариуцсан чиг үүргийн хүрээнд албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг тухай бүр боловсруулан тайлагнаж ажилласан. Үүнд соёл урлагийн үйлчилгээнд хамрагдсан үзэгчдийн тоо, урын сан болон тоглолтын тоо, хүний нөөц, санхүү зэрэг үзүүлэлтээр бүрэн задаргаатай статистикийн мэдээллийг улирал бүр гарган, холбогдох байгууллагад хүргүүлсэн. Мөн Дотоод ажил, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн Б.Өнөрцэцэг статистикийн мэдээлэл боловсруулах, тайлагнах шинэлэг тогтолцоог нэвтрүүлэх, албан хаагчдыг сургахад анхаарч ажиллаж байна. Хэрэгжилт 100%

Гүйцэтгэлийн зорилт 4.12. Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулна, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Хүрэх түвшин: Хамтын ажиллагааны хэрэгжилтийн хувь 100

Биелэлт: Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өгч байгаа "Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах" чиглэлийн дагуу театрын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар SWOT шинжилгээ хийгдэж байна. Тус ажлын хэсгийг Захиргааны ахлах мэргэжилтэн Б.Түмэндэлгэр хариуцан ажиллаж байна. Байгууллагын стратеги төлөвлөгөөг

хийж, НЗДТГ -ын Төрийн Захиргаа удирдлагын газарт хянуулж дуусгасан бөгөөд батлуулах шатандаа явж байна. Хэрэгжилт 100%

Гүйцэтгэлийн зорилт 4.13. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030” оны хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.




Хүрэх түвшин: Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 100

Биелэлт: “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр нь төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, төлөвшүүлэх, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн 2024-2030 онд хэрэгжих дунд хугацааны хөгжлийн зорилтот үр дүнд хүрэхийг зорьж, Ёс зүйн дэд хороо нь 6 хүний бүрэлдэхүүнтэй соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, албан хаагчдын ёс зүйн чадамжийг өндөр түвшинд хүргэх чиглэлээр төлөвлөгөө гарган, 2025 он 03 сарын 01-ний өдөр театрын даргаар батлуулан хэрэгжүүлж ажилласан. Хэрэгжилт 50%.

Гүйцэтгэлийн зорилт 4.14. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024-2030” хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.

Хүрэх түвшин: Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 100

Биелэлт: “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024-2030” хөтөлбөрийн хүрээнд театрын 2025 оны 01 сарын 22-ны өдөр батлагдсан “Авлигын эсрэг” төлөвлөгөө гарган төлөвлөгөөт ажлын хүрээнд албан хаагчид “Авлигын эсрэг уриан дор нэгдэж төр, захиргааны олон байгууллагад авлигаас ангид албан хаагч уриан дор цахим орчинд 1 минутын геел бичлэг хийж <https://ubtheatre.mn/> цахим орчинд түгээн дэлгэрүүлж уриалан авлигатай тэмцэх ажилд соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Ажлын байр ба баг хамт олны үр дүнтэй харилцаа” сургалтад албан хаагчдаа хамруулж ажилласан. Хэрэгжилт 100%.



Гүйцэтгэлийн зорилт 4.15. Театрын үйл ажиллагааны орлого болон уран бүтээлийн орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч, орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу ханган биелүүлж ажиллана.

Хүрэх түвшин: Төвлөрүүлсэн орлогын хэмжээ 150.0 сая төгрөг

Биелэлт: 2025 онд 150 сая төгрөгийг Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөөтэй бөгөөд энэхүү орлогыг бүрдүүлэх гол хүчин зүйл болох тайз түрээсийн үйлчилгээ 2025 оны 5 дугаар сараас эхлэн 10 дугаар сарын дунд үе хүртэл их засварын ажлын улмаас зогсонги байдалтай байсан. 2025 оны 12 дугаар сарын байдлаар 111,5 сая төгрөгийг Нийслэлийн төрийн санд төвлөрүүлж ажилласан. Хэрэгжилт 75%

Гүйцэтгэлийн зорилт 4.16. Ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангуулж, үйлдвэрлэлийн осолгүй ажиллана.

Хүрэх түвшин: Үйлдвэрийн ослын тоо 0

Биелэлт: Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж өдөр тутмын хяналт шалгалтыг тухай бүр хийж гүйцэтгэн шаардагдах хэрэгцээ бүхий зүйлсийг түргэн шуурхай шийдэж албан хаагч бүрийн аюулгүй байдлыг хангах “ХАБЭА менежмент” хуваарийг театрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Урьдчилсан зааварчилгааг улирал тутам албан хаагч бүрт өгч, эрсдэлээс хамгаалах санамж зөвлөгөөг өгч ажиллаж хэвшсэн. Эрсдэлтэй ажлын байранд өдөр тутмын шалгах хуудас, аюулгүй ажиллагааны зааварчилгаа зэргийг үндэслэж, гарч болох хохирлоос урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд үйлдвэрлэлийн осолгүй ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн Б.Бүрэнжаргал 7 дугаар сард ажлаас чөлөөлөгдөж, 8 дугаар сараас эхлэн тус ажил үүргийг Д.Бямбаа хариуцан гүйцэтгэж байна. Хэрэгжилт 100%

Гүйцэтгэлийн зорилт 4.17. Албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгт хамруулна.

Хүрэх түвшин: Үзлэгт хамрагдсан албан хаагчийн тоо 100

Биелэлт: Театрын бүтэц орон тоонд өөрчлөлт орж, ажилтан албан хаагчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой албан хаагчдын эрүүл мэндийг сахин хамгаалах, эрүүл-цэвэр-тав тухтай ажлын байраар хангахын тулд ХАБЭА хариуцсан мэргэжилтэн, хүний их эмчийн орон тоог батлуулж, ажиллуулж эхлээд байна. 2025 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр Бие бялдрын хөгжил, тэсвэр хатуужлыг тодорхойлох сорил авч, Эрүүл мэнд, эрүүл амьдралын хэв маяг эмийн зохистой хэрэглээ, Артерийн даралтаа хянах сэдвүүдээр сургалтыг нийт албан хаагчдад зохион байгуулсан. Эрүүл мэндийн Сайдын 2014 оны 10-дугаар сарын 20-ны өдрийн А/340 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад заасны дагуу албан хаагчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг буюу өвчнөөс урьдчилан сэргийлэх нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, онош зүйн болон лабораторийн шинжилгээ хийлгэх ажлыг жил бүр СБДНЭ-тэй хамтран зохион байгуулж ажилладаг. Энэ жилийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгийн ажлыг 2025 оны 12 дугаар сарын 9-12-ны өдрүүдэд 82 албан хаагчийн хамруулан ажиллаж байна. Хэрэгжилт 100%





Гүйцэтгэлийн зорилт 4.18. 2015-2022 оны архивын баримтаар төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх.

Хүрэх түвшин: Хамтын ажиллагааны хэрэгжилтийн хувь 100

Биелэлт: “Төрийн Архивд баримт шилжүүлэхэд байнга, 70 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгах хэргийн жагсаалтыг төрийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хянуулж батлуулсан байна” гэж заасны дагуу тус байгууллагын архивд хадгалагдаж байгаа 2006-2022 оны 919 баримтад иж бүрэн нягтлан шалгалт, техник боловсруулалтыг хийж Нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК-ын 2025 оны 01 дүгээр хурлаар дараах данс, бүртгэл, устгах баримтын жагсаалтыг хэлэлцүүлж батлуулж байнга хадгалах 2015-2022 оны 196, захирамжлалын 2015-2022 оны 16, дүрс бичлэгийн 38, цахим гэрэл зургийн байнга хадгалах 2014-2022 оны 15, батлуулж төрийн архивд 265 хадгаламжийн нэгж шилжүүлж актаа хүлээн авсан. 70 жил хадгалах 2006-2022 оны 78, түр хадгалах 2009-2022 оны 294, баримтын бүртгэлийг байгууллагын архивд хадгалахаар баталсан. Нийслэлийн архивын газрын 2025 оны 05 сарын 2-ны өдрийн 01/488 тоот албан бичгээр баримт бичиг хүлээлгэн өгөх хуваарийн дагуу 2025.05.29-ны өдөр төрийн архивд байнга хадгалах 2015-2022 оны 196 хадгаламжийн нэгжийг хүлээлгэн өгөв. Мөн Улаанбаатар театрын даргын 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/09 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, 2006-2021 оны 32 хэргийн 146 баримтын устгах ажлын хэсгийн бүрэлдэхүүн устгах баримтыг задалж хавтаснаас нь салгаж цаас устгагчаар устгаж, мөн ихэнх хэсгийг ажлын хэсгийн бүрэлдэхүүн авч явж, протокол үйлдэн шатааж устгасан. 2006-2022 оны төрийн архивын нөхөн бүрдүүлэлтийн ажил хэрэгжиж дууссан. Хэрэгжилт 100%



Гүйцэтгэлийн зорилт 4.19. Театрын үйл ажиллагааны сар, улирал, хагас бүтэн жилийн хугацаат тайлан мэдээг гаргаж, хугацаанд нь тайлагнаж ажиллана.

Хүрэх түвшин: Хамтын ажиллагааны хэрэгжилтийн хувь 100

Биелэлт: 2025 онд нийт 4 төлөвлөгөө, 40 төрлийн тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Үүнд: “2025 оны Статистик мэдээг улирал бүрээр”, “2025 оны Санхүүжилтийн тайлан”, “Авилгалын төлөвлөгөө, “Харилцан хүндэтгэе” Жендэрийн тайлан, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан”, Ахмад настнуудад зориулж хийсэн ажлын тайлан, Соёлын бүтээлч сарын тайлан, “2025 оны 06 сараас 12 сар хүртэлх Засаг даргын шуурхайн үүрэг даалгаврын хэрэгжилт”, “2025 оны Хөгжлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлт”, Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдсэн тухай илтгэх хуудас, “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-ний хагас жилийн хэрэгжилт, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлан, Ёс зүйн тайлан зэрэг тайлан мэдээг цаг хугацаанд нь тайлагнан ажилласан. Хэрэгжилт 100%

Гүйцэтгэлийн зорилт 4.20. Байгууллагын Албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт <https://edoc.ulaanbaatar.mn/> системийн ашиглалтыг сайжруулж, зөрчилгүй ажиллана.

Хүрэх түвшин: Зөрчлийн тоо 0

Биелэлт: Албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, судалж шийдвэрлэх, хариу өгөх болон мэдээлэл-лавлагаанд шаардлагатай бүх баримт бичгийг хүлээн авч, бүртгэн үйл ажиллагааг edoc.ulaanbaatar.mn онлайн нэгдсэн системээр хөтлөн явуулж байна. 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар системээр 263 албан бичиг бүртгэгдсэн. Үүнээс байгууллагаар бүртгэгдсэн 6 албан бичиг, хариутай-55, хугацаандаа шийдвэрлэсэн 54. Хариутай бичгийн шийдвэрлэлт 100%, хариугүй 202 бичиг, шийдвэрлэлт 100% байна. Мөн 208 албан бичиг явснаас, хариутай бичиг 10, хариугүй бичиг 198. Шийдвэрлэлт 100% байна. Тайлант хугацаанд 18 зөрчил гарсан. Үүнд албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчил 14, стандартын зөрчил 4 байна. Эдгээр зөрчилтэй ажилласан албан хаагчдад ажил сайжруулж, цаашид зөрчил гаргахгүй ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнээс анхааруулав. Хэрэгжилт 70%

Гүйцэтгэлийн зорилт 4.21. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, дүрэм журмыг мөрдөж ажиллах, албан хэрэг хөтлөлтийг кирил, үндэсний хос бичгээр хөтлөн явуулахтай холбоотой албан хаагчдыг сургалт, арга зүйгээр хангах.

Хүрэх түвшин: Сургалтын тоо 4

Биелэлт: 2025 оны 02 сарын 13-ны өдөр Нийслэлийн архивын газраас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн хос бичгээр хөтлөх тухай” сургалтад хамрагдан сургалтын дагуу байгууллагын захиргааны 7 албан хаагчид хос бичгээр албан хэрэг хөтлөх тухай сургалт зохион байгуулав. Мөн “Болорсофт” ХХК-тай гэрээ хийж Кимо хөрвүүлэгч программ авч Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, дүрэм журмыг мөрдөн ажиллаж үндэсний хос бичгээр албан хэргээр хөтлөн явуулж байна. Түүнчлэн, Монгол хэлний тухай хууль тогтоомж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахаар төлөвлөгөө боловсруулан театрын даргаар 2025 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр батлуулсан. Тус төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 50%-ийн хэрэгжилттэй ажиллаж байна. Театрын Дотоод ажил тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн Б.Өнөрцэцэг нь монгол бичгийн суурь мэдлэг сайтай, хосолмол бичгээр албан хэрэг хөтлөн явуулах туршлагатай албан хаагч тул театрын Эх зохиогчийн албан үүргийн хавсруулан гүйцэтгүүлэхээр театрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Б/100 дугаар

Удирдах дээд байгууллагуудаас зарласан танхимын болон цахим сургалтад давхардсан тоогоор 109 албан хаагчийн хамруулж ажиллалаа. Хэрэгжилт 100%

Гүйцэтгэлийн зорилт 4.23. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд дотоод хяналт шинжилгээ-үнэлгээ хийх ажлыг эрчимжүүлж ажиллана.

Хүрэх түвшин: Зөвлөмж өгсөн ажлын тоо 6

Биелэлт: Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа болон байгууллагаас гарч байгаа мэдээ тайланд Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн төлөвлөгөөний дагуу хяналт тавьж ажилладаг. Театрын “Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээг зохион байгуулах журам” болон Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод Монгол Улсын Соёлын яамнаас ирүүлсэн соёлын байгууллагуудад өгсөн үлгэрчилсэн загварын дагуу нэмэлт өөрчлөлт оруулж, байгууллагын дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг илүү нарийвчилсан хэлбэрээр явуулахаар ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан 9 ажлын 4 ажилд удирдамжийн дагуу хяналт тавьж, зөвлөмж өгч ажилласан. Шалгалтын явцад ноцтой илэрсэн зөрчил байхгүй. Хэрэгжилт 100%

Гүйцэтгэлийн зорилт 4.24. Байгууллагын хагас, бүтэн жилийн тайлан мэдээнд хяналт шинжилгээ хийнэ. (Засгийн газрын 206 дугаар тогтоолоор)

Хүрэх түвшин: Гүйцэтгэлийн хувь 100

Биелэлт: Байгууллагын 2025 оны хагас жилийн тайлан мэдээнд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийг гаргаж батлуулсан. 2025 онд театрын удирдлага Нийслэлийн Засаг даргатай байгуулсан “Хариуцлагын гэрээ” түүний хавсралт болох “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 6 зорилтын хүрээнд нийт 46 ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар дээрх 46 ажлыг 63%-ийн гүйцэтгэлийг ханган ажилласан байна. Бүтээгдэхүүн тус бүрээр дүгнэвэл 100%-14, 90%-2, 70%-7, 50%-14, 30%-4, 0-10%-ийн хэрэгжилттэй 5 ажил байна. Тус 0-10%-ийн хэрэгжилттэй 5 ажил нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна. Театрын байранд их засварын ажил хийгдэж, уран бүтээлийн ажлууд хэвийн хэмжээнд явагдах боломжгүй байгаагаас зарим ажлын гүйцэтгэлийн биелэлт дутуу хэрэгжээд байна. Хэрэгжилт 100%

Гүйцэтгэлийн зорилт 4.25. Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын “Мод тарих өдөр”-өөр театрын модны талбайд модны усалгаа, арчилгаа, нөхөн сэргээлт хийнэ.

Хүрэх түвшин: Хэрэгжүүлэх ажлын тоо 4

Биелэлт: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны 05 дугаар 04, 10 дугаар сарын 14-ний өдрүүдэд буюу хавар, намрын цагаар жилд 2 удаа Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Айдсын ам гэх хэмээх нийслэлийн байгууллагуудын моджуулах талбайд байрлах төгөлдөө театрын албан хаагчид өөрсдийн тарьсан модоо арчилж, зэрлэг өвс, хог хаягдлыг цэвэрлэн, усалгааны ажлыг зохион байгуулж ажиллав. Тус талбайд 2020 оноос мод тарьж эхэлсэн бөгөөд жилээс жилд тарьсан модоо арчлах, сэргээх, нөхөн тарилт хийх зэргээр театрын албан хаагчид ажиллаж хэвшсэн. Одоогоор тус талбайд хайлаас, бургас, монос, улиас, голт бор зэрэг 5 төрлийн 160 гаруй модтой. Хэрэгжилт 100%

Гүйцэтгэлийн зорилт 4.26. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төлөвлөгөөт ажил зохион байгуулж ажиллана.

Хүрэх түвшин: Зохион байгуулсан ажлын тоо 4

2025 оны 11 дүгээр сарын 10-нд Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд “Хүйс ба жендэрийн ялгаа”, “Жендэрийн үүрэг, жендэрийн хэвшмэл

ойлголт”, “Жендэрийн тэгш байдал” сэдэвт 1 удаагийн сургалтыг Жендэрийн сургагч багш Б.Өнөрцэцэг байгууллагын нийт 15 албан хаагчид орсон.



Биелэлт: “Жендэрийн үндэсний Хорооноос 2025 оны 11 дүгээр сарын 25-аас 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-д нэгдэж байгууллага дотроо постер байрлуулж, ERP, Улаанбаатар театр Фэйсбүүк, Улаанбаатар театр пэйжүүдээр сурталчлан түгээж байна. Хэрэгжилт 100%



модуль 1. жендэрийн ойлголт

ХИЧЭЭЛ 1: ХҮЙС БА ЖЕНДЭРИЙН ЯЛГАА

ХИЧЭЭЛ 2: ЖЕНДЭРИЙН ҮҮРЭГ, ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ


ХИЧЭЭЛ 3: ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ

Сургагч багш Б.Өнөрцэцэг



Жендэрийн тэгш байдал

Сургагч багш Б.Өнөрцэцэг




Зорилт 5: Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Гүйцэтгэлийн зорилт 5.1. Иргэдийн эрэлт хэрэгцээ, оюуны шаардлагад нийцсэн шинэ уран бүтээл туурвих болон урын сангийн бүтээлийг сэргээж үзэгчдийн хүртээл болгоно.




Хүрэх түвшин: Бүтээлийн тоо 4

Биелэлт: Нийслэлийн иргэдийн соёл урлагийн хэрэгцээг хангах, театрын урлагаар дамжуулан соёлын боловсрол олгох, иргэдийн эрэлт хэрэгцээ, оюуны шаардлагад нийцсэн бүтээл туурвих зорилгоор "Маппет хүүхэлдэйн театр"-тай хамтран 2025 онд "Цаст Сарьдагийн Олмасс" хүүхдийн жүжгийг бүтээсэн. Тус жүжгийн бэлтгэл ажил 03 дугаар сараас эхэлсэн бөгөөд анхны танилцуулах тоглолтоо 2025 оны 06 дугаар сард Хүүхдийн баярын арга хэмжээнд зориулан "Хүн" театрын тайзнаа хэсэгчилсэн хэлбэрээр анхны үзэгчдэдээ толилуулсан.



Мөн иргэдийн эрэлт хэрэгцээ, оюуны шаардлагад нийцсэн бүтээл туурвих зорилгын хүрээнд урлагийн олон талт тоглолт буюу ардын урлаг, сонгодог урлаг, орчин үеийн урлагийг нэгтгэсэн "Хүрээ ба Классик" тоглолтыг 2025 онд 2 удаа зохион байгуулсан. Тус тоглолтод дээрх урлагийн төрлүүдийг бүжиг, дуу, хөгжмөөр илэрхийлсэн шилдэг номеруудыг шинэчлэн найруулж, гэрэлтүүлэг, дэлгэцийн урлагтай хослуулан олон нийтэд хүргэсэн. Хүүхдүүдэд театрын урлагаар дамжуулан соёлын боловсрол олгох зорилгоор "Маппет" театрттай хамтран "Гринч", "Коко" гэх хүүхдийн хөгжөөнт жүжгийг амралтын өдрүүдэд тогтмол тайзнаа тоглосон. 2025 оны 12 дугаар сарын 12-нд "Монгол бахархал" уриатай "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд Нийслэлийн Улаанбаатар театрын уран бүтээлчид ардын урлаг, сонгодог урлаг болон орчин үеийн урлагийн сор болсон

бүтээлүүдийг нэгэн тайзнаас хүргэх өвөл цагийн нээлтийн тоглолтоо үзэгч түмэнд хүргэхээр бэлтгэл ажилдаа орон ажиллаж байна. Хэрэгжилт 100%



Гүйцэтгэлийн зорилт 5.2. Нийслэлийн өмчийг зориулалтын дагуу ашиглаж, ашиглалтын байдалд хяналт тавих, хадгалах, хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ авна.

Хүрэх түвшин: Хэрэгжилтийн хувиар

Биелэлт: Улаанбаатар театрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/30 дугаар тушаалаар театрын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус зөвлөл нь төлөвлөгөө гарган ажилладаг. Өмч хамгаалах байнгын зөвлөл нь байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж хөрөнгө актлах, засварлах, хөрөнгө хүлээн авах үйл ажиллагааг мөрдлөг болгон ажилладаг, зөвлөлийн дэргэдэх техникийн дүгнэлт гаргах ажлын хэсгийн гишүүд тайзны гэрэл шум, оффисын тоног төхөөрөмж, чавхдаст хөгжмүүдэд үзлэг хийж “Суунаг сутай” ХХК-аар тайзны тоног төхөөрөмж болох дижитал пульт, тэжээлийн блокын засвар, Квант сервис ХХК-аар Оффисын компьютерын хэрэглээний засвар үйлчилгээг, Хан мюзик ХХК, Консонанс ХХК-аар чавхдаст хөгжмийн засвар үйлчилгээг хийлгэсэн. Мөн театрын даргын 2025 оны А/11 дүгээр тушаалаар “Маппет хүүхэлдэйн театр” ХХК-тай хамтран ажиллах гэрээний дагуу





нийлүүлэгдсэн AKG брэндийн микрофоныг хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн авсан. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтэй холбоотой “Улаанбаатар театр”-ын балансаас, “Налайх дүүргийн Соёлын ордон”-руу балансад шилжсэн их танхимын 420 ширхэг үзэгчдийн сандлыг НӨХГ-ын даргын А/114 дүгээр тушаалыг үндэслэн театрын даргын А/19 тоот тушаалаар эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээс хассан. “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн хурлын шийдвэрээр НӨХГ-т хүргүүлсэн эргэлтийн бус хөрөнгийг НӨХГ-ын А/155 дугаар тушаал, театрын даргын 2025 оны А/30 дугаар тушаалаар үлдэх өртөггүй болсон анхны үнээ элэгдлээрээ нөхсөн 31 нэр төрлийн 196,859,383 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгаж, хяналт тавьж ажилласан. 2025 онд батлагдсан төсөв, хөтөлбөр эдийн засгийн ангиллын дагуу уран бүтээлчдийн хувцсыг шинэчлэх ажлын хүрээнд Талын болор ХХК, Ингүүн мед ХХК, Мерам дизайн ХХК-аас үнийн



санал авч, Мерам дизайн ХХК нөхцөл ханган шалгарч нийт 8 нэр төрлийн 35 ширхэг уран бүтээлчдийн хувцас, гутлыг, НЗД-ын А/833 дугаар захирамж, театрын даргын 2025 оны А/20 дугаар тушаалаар Юппи ХХК-аас нийлүүлсэн 45,000,000 төгрөгийн үнэ бүхий “21 Дарь эх”, “Их хурд” бүжигчдийн нийт 2 төрлийн 45 ширхэг тоглолтын хувцсыг, НЗД-ын А/902 дугаар захирамж, театрын даргын 2025 оны А/21 дүгээр тушаалаар “Нинжээгийн оёдол” ХХК-аас нийлүүлсэн 36,000,000 сая төгрөгийн үнэ бүхий поп оркестрын 20 ширхэг тоглолтын хувцас, “Жаак энд жүки” ХХК-аас нийлүүлсэн 36,000,000 сая төгрөгийн үнэ бүхий поп оркестрын 20 ширхэг платье, “Удмын урлан ХХК-аас нийлүүлсэн 40,260,000 мянган төгрөгийн үнэ бүхий “Хангарди” оркестрын 32 ширхэг иж бүрэн дээл, “Үүлэн гутал” ХХК-аас

13,140,000 мянган төгрөгийн үнэ бүхий 32 ширхэг тоглолтын хос гутлыг “Эргэлтийн бус хөрөнгө”-ийг жагсаалтын дагуу тус тус данс бүртгэлд бүртгэн авч ашиглалтад оруулсан тухай акт үйлдэж ашиглагдах жилийг тооцож хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавьж ажилласан. Мөн НЗДТГ-аас “Улаанбаатар театр”-т 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдөр нийлүүлсэн нийт 73,615,500 төгрөг бүхий 15 ширхэг суурин компьютерыг НӨХГ-ын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1/1930 тоот бичгийн дагуу театрын даргын А/32 тоот тушаалаар тоног төхөөрөмж ашиглалтад оруулсан акт үйлдэн хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн авсан. Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2025 оны бүтэн жилийн хугацаанд батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, эд хөрөнгийн бүртгэл, хамгаалалт, хяналтыг сайжруулахад бодитой үр дүн гаргаж ажилласан. Хэрэгжилт 100%



Гүйцэтгэлийн зорилт 5.3. Ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, хамтарсан уран бүтээл туурвина.

Хүрэх түвшин: Хамтарсан уран бүтээлийн тоо 3

Биелэлт: 2025 оны 3 дугаар сарын 15-ны өдөр “Хүн театр”, “Хан Хэнтий” чуулгын бүжигчидтэй хамтран “Үлэмж төгөлдөр” ашгийн бус тоглолт, Дэлхийн бүжигчдийн өдрийг угтан 4 дүгээр сарын 21-ний өдөр Дуурь бүжгийн эрдмийн театрын тайзнаа Монголын Урлагийн зөвлөлтэй хамтран “Ариун хаврын тахилга” бүтээлийг Бүжиг дэглээч Б.Одбаярын тавилтаар контемперари хэлбэрээр үзэгч олны хүртээл болгосон. Энэхүү уран бүтээлд

Хангарди үндэсний найрал, бүх бүжигчид оролцон тоглосон. 2025 оны 04 дүгээр сарын 19-20-ний өдрүүдэд Organizers, Arts Council of Mongolia, Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн



Театртай хамтран Моушн Монголиа" олон улсын орчин үеийн бүжгийн наадам 2025 "ТОЙРОГ" бүжгийн тоглолтыг амжилттай зохион байгуулж ажилласан. 2025 оны 05 дугаар сарын 05-ний өдөр "Соёмбын дуулал магтуу" Таван нүдэн брэнд болон Монгол Улсын консерватортой Чингис хааны музейд уран бүтээлийн хамтарсан тоглолтыг зохион байгуулж ажилласан. 2025 оны 8 сарын 11-13-ний хооронд Монголын хүүхдийн ордонд Бүгд найрамдах Солонгос улсын хөгжимчидтэй хамтарсан уран бүтээлийн тоглолтыг зохион байгуулсан. 2025 оны 11 сарын 14-ний өдөр Өндөр гэгээн Занабазарын 390 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээнд Гандантэгчэнлин хийд болон нийтийн дуучидтай хамтарсан арга хэмжээнд оролцсон. Хэрэгжилт 100%




Гүйцэтгэлийн зорилт 5.4 Нийслэлийн хэмжээнд зохион байгуулж байгаа соёл урлагийн олон талт үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

Хүрэх түвшин: Оролцсон үйл ажиллагааны тоо 14

Биелэлт: Нийслэлийн Улаанбаатар театрын уран бүтээлийн баг Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулдаг гадаад дотоодын зочдын хүндэтгэлийн хүлээн авалтын арга хэмжээ, Нийслэл хотын үзэгчдэд соёл урлагаар үйлчлэхийн зэрэгцээ НЗДТГ, НЗАА, НИХТ болон тэдгээрийн харьяа газар, хэлтсүүд, мөн ЕТГ, ГХЯ-ны захиалгаар зөвхөн нийслэл хотод нийт 72 удаагийн тоглолтыг хийж энэхүү тоглолтод нийт 320 гаруй уран бүтээлчид оролцон давхардсан тоогоор 25.000 гаруй үзэгчдэд урлаг соёлын үйлчилгээ үзүүлж ажилласан байна. Нийслэлээс зохион байгуулсан Сар шинийн баярт зориулсан "Амар байна уу" үзэсгэлэн худалдаа, өвлийн "Нүүдэлчин" фестиваль, "Их хотын бүсгүйчүүд" арга хэмжээ, Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан "Хоолны фестиваль"-ийн 6 өдрийн тоглолт, "Шагайн харваа" өдөрлөгийн 2 өдрийн тоглолт, Нийслэлийн иргэдийн баяр Хүрээ цам-Даншиг наадам, Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг Ширээт Цагаан нуурын хөвөөнд гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд уран бүтээлчид оролцсон. Мишээл Экспод зохион байгуулсан "ITM MONGOLIA EXPO 2025"-олон улсын үзэсгэлэн худалдаа, "БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ-ТӨРИЙН АЛБАНЫ МАНЛАЙЛАЛ" нийслэлийн бүсийн зөвлөгөөний оролцогчдод зориулан тоглолт зэрэг 20 гаруй томоохон арга хэмжээнүүдэд хэсэгчилсэн болон бүрэн бүрэлдэхүүнээр оролцон, уран бүтээлээ толилуулсан байна. Хэрэгжилт 100%





Гүйцэтгэлийн зорилт 5.5 Соёл урлагийг хөгжүүлэх үйл хэрэгт тодорхой хувь нэмэр оруулсан албан хаагчдыг төр, засгийн болон нийслэлийн шагналаар шагнуулах талаар хүсэлт, тодорхойлолт гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлнэ.

Хүрэх түвшин: Шагналд тодорхойлсон албан хаагчийн тоо 10

Биелэлт: Соёл урлагийг хөгжүүлэх үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулсан 2 уран бүтээлчийг Монгол Улсын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас жил бүр зохион байгуулдаг “Оны шилдэг уран бүтээлч” шалгаруулах “Мөнгөн мод” цомын эзнээр тодруулах шагналд тодорхойлж, бичиг баримтыг бүрдүүлэн хүргүүлснээс Гоцлол дуучин А.Отгонболд тус шагналын эзэн болсон. Мөн албан хаагчдын дунд шагналын судалгааг хийж ажилласан. Тус судалгаагаар нийслэлийн шагналаар шагнуулах болзол хангасан 4, Засгийн газрын шагналаар шагнуулах болзол хангасан 2 албан хаагч байсны дагуу Засгийн газрын шагнал болон бусад шагналаар шагнаж урамшуулахаар 16 албан хаагчийн материалыг бүрдүүлж холбогдох газарт хүргүүлсэн. Ингэснээр Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан цол, тэмдгээр Тайз үйлдвэрлэлийн ангийн дарга Ц.Батцэнгэл, дуучин Х.Мөнхтүвшин, гоцлол дуучин А.Отгонболд, морин хуур хөгжимчин Т.Санжаажамц, ССАЖЗЯ-ны “Жуух бичиг”-ээр гоцлол дуучин Г.Алтанхуяг, бүжигчин Г.Аззаяа, О.Ганзаяа, хөгжимчин Э.Намуундарь, НСУГ-ын “Хүндэт өргөмжлөл”-өөр лимбэ хөгжимчин Ц.Амина, морин хуур хөгжимчин А.Баярмаа, Б.Бишрэлт-Азбаяр, ёочин хөгжимчин У.Номин-эрдэнэ нарын 12 албан хаагч шагнуулсан. Хэрэгжилт 100%





Гүйцэтгэлийн зорилт 5.6. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн бусад үзүүлэлтэд хамаарах чиглэлээр олон талт ажил зохион байгуулж ажиллана.

Хүрэх түвшин: Санаачлан хэрэгжүүлсэн ажлын тоо 4

Биелэлт: Чингис хааны музей, Таван нүдэн ХХК-тай хамтран 2025 оны 05 дугаар сарын 05-ны билэгт сайн өдөр Анхдугаар Богд Жэвзүндамба хутагт, Өндөр Гэгээн Занабазарын мэлмий гийсний 390 жилийн ойд зориулан “Таван нүдэн” брэндийн захиалгаар Монголын хөгжмийн зохиолчдын холбооны тэргүүн, хөгжмийн зохиолч Г.Төвшинтөрийн хөгжим, Хэл шинжлэлийн ухааны доктор Д.Даваасүрэнгийн цомнол “СОЁМБО” магтуу /оратори/ бүтээлийг нийт дуучид, “Хангарди” үндэсний найрал хөгжмийн уран бүтээлчид эгшиглүүлэн, анх удаа олон нийтэд хүргэсэн. Энэхүү бүтээл нь хөгжмийн болон дууны нэлээд томоохон мэргэжлийн бүтээлд тооцогдох хэмжээний бүтээл болж, үзэгч олноос өндөр үнэлгээ авсан. Мөн Проспер Меримейн туужаар Анри Мейлк, Людовик Алеви нарын бичсэн цомнолоор Францын алдарт хөгжмийн зохиолч Жорж Бизегийн хөгжмийг нь зохиосон “Кармен” 4 бүлэгт дуурийг 2025 оны шинэ уран бүтээлийн төлөвлөгөөндөө оруулан тоглохоор 09 дүгээр сараас эхлэн бэлтгэл ажилдаа орсон. Энэ удаагийн тавилтаар Кармен дуурийг нийтлэг тоглогддог тавилаас шинэчлэн үйл явдал өрнөх цаг хугацааг 100-аад жилээр хойшлуулж ХХ зууны эхний хагаст болж буйгаар шинэчлэн найруулан тайз болон хувцас хэрэглэлийг минимал хэлбэрээр тавихаар зорьж байгаа билээ. Тус дуурийг 2026 оны 2 дугаар сарын 05, 06-ны өдөр тайзнаа тоглохоор бэлтгэл ажил хангагдаж байна. Хэрэгжилт 100%

Гүйцэтгэлийн зорилт 5.7. Тухайн жилийн санхүүгийн тайланг, Нийслэлийн төрийн сангийн хэлтэст хянуулж ажиллана.

Хүрэх түвшин: Тайлант ажлын тоо 4

Биелэлт: 1, 2, 3-р улирлын санхүүгийн тайлан Нийслэлийн төрийн сангийн хэлтэст хянуулж баталгаажуулан ажилласан. Хуулийн хугацаагаар 4-р улирлын санхүүгийн тайланг 2026 оны 01 сарын 25-нд Нийслэлийн төрийн сангийн хэлтэст хянуулж нэгтгүүлдэг. 4-р улирлын санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн ажил 100 хувьтай явагдаж байна. Хэрэгжилт 100%

Зорилт 6. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах үйл ажиллагаа


Гүйцэтгэлийн зорилт 6.1. Хэрэглэгчдээс бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх судалгааг авч, судалгааны үр дүнд суурилан уран бүтээлийн сонголт болон борлуулалтад нөлөөлөх, театрын үйл ажиллагааны суурь судалгаа болгон ашиглана.

Хүрэх түвшин: Судалгаа, Зохион байгуулсан ажлын тоо 2


Биелэлт: Нийт 300 гаруй үзэгчдээс бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх судалгаа авснаар үзэгчдийг сонгодог төрлийн бүтээлд "илүү сонирхолтой байна" гэх үр дүн гарсан. Энэ үр дүнд суурилан дэлхийн сонгодог бүтээлийг шинэчлэн найруулж, поп оркестртой болон амьд хөгжмийн хамтлагтай хамтран "DUO TENOR" оператик поп концертыг театрын өвөл цагийн нээлт болгон 2 удаа тайзнаа тоглосон. Дээрх тоглолтыг үзсэн үзэгчдээс дахин сэтгэл ханамжийн судалгаа авч, үзэгчид сонгодог урлагийн тоглолтыг илүүтэй шимтэн үзэж байгаад үндэслэн 2026 оны хавар цагийн нээлт болгож "Кармен" сонгодог дуулалт жүжгийг тайзнаа тавихаар театрын уран бүтээлчид бэлтгэл ажилдаа орсон байна. Хэрэгжилт 85%

Үзэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа: Судалгаагаар үзэгчид сонгодог урлагийн тоглолт илүүтэй шимтэн үзэх сонирхолтой байгаа нь гарч ирсэн бөгөөд үүнийгээ дагаад театрт үзвэр, тоглолт үзэх үзэгчдийн насны ангиллын дийлэнх нь буюу 44.8% нь 36-45 насныхан байна. 2025 онд театр их засвар хийсэнтэй холбогдуулан танхимын тав тух, гэрэл, хөгжим техникийн дуугаралт сайн болсныг үзэгчид илэрхийллээ. Үүнийгээ дагаад тайзнаа тавьж буй тоглолтын чанар сайжирсныг судалгаанаас харж болно.


1. Таны нас?




Танхимын суудлын тав тух танд хэр таалагдсан бэ?



Уран бүтээлийн чанарыг үнэлнэ үү.



Урьдчилсан мэдээлэл (зураг, трейлер, тайлбар) хангалттай байсан уу?



Гүйцэтгэлийн зорилт 6.2. Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд зөрчилгүй шийдвэрлэж ажиллана.

Хүрэх түвшин: Зөрчлийн тоо 0

Биелэлт: 2025 оны жилийн эцсийн байдлаар албан хаагчдаас ирүүлсэн нийт 5 өргөдөл бүртгэгдсэн бөгөөд эдгээр өргөдлийг хуулийн хугацаанд багтаан 100 хувь шийдвэрлэсэн.

Шийдвэрлэлтийн явцад илэрсэн зөрчилгүй ажилласан. Бүртгэгдсэн өргөдлүүдийн төрлөөр нь ангилбал, Хөгжимчин Д.Ганзол хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа эргэн орох тухай, Гэрлийн оператор О.Номин-Эрдэнэ гадаад оронд суралцахтай холбоотой хувийн чөлөө авах тухай, Театрын эмч Д.Намжаа нь мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх зорилгоор АШУҮИС-ийн резидентийн ангид суралцахтай холбоотойгоор ажлын цаг богиносгох тухай, ХАБЭА хариуцсан мэргэжилтэн Д.Бямбаа нь эрүүл мэндийн шалтгаанаар гадаад оронд эмчлүүлэхээр цалинтай чөлөө хүсэх тухай, Туслах найруулагч Ц.Баярсайхан эрүүл мэндийн шалтгаанаар ажлаас чөлөөлөгдөх тухай нийт 5 өргөдлийг бүртгэн авч, холбогдох журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. Хэрэгжилт 100%

Гүйцэтгэлийн зорилт 6.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ажил, үйлчилгээг дэмжиж ажиллана.


Хүрэх түвшин: Хэрэгжүүлэх ажлын тоо 4

Биелэлт: Нийгмийн хариуцлагын хүрээнд Хавдар судлалын Үндэсний төв эмнэлэгтэй хамтран хорт хавдраар өвдсөн иргэдийг “Хөгжмөөр Эмчлэхүй” зорилтот тоглолтыг 3 дахь жилдээ хамтран зохион байгуулж тайлант хугацаанд 6 удаагийн тоглолтыг зохион байгуулж ажилласан. Энэ хугацаанд 28 уран бүтээлч оролцон давхардсан тоогоор 500 гаруй хүнд үйлчилсэн байна. Мөн, Сонгинохайрхан дүүргийн халамжийн төвөөс зохион байгуулсан Баянхошуу, зүүн Баруун салааны хороодын өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, амьдралын түвшин доогуур үзвэр үзэх боломжгүй иргэдийг хамруулсан тоглолтод тусгайлан зориулсан хөтөлбөр бэлтгэж 300 гаруй иргэдэд үйлчилсэн. Түүнчлэн НЗДТГ-ын дэргэдэх “Нийгмийн хөгжлийн тусгай төв”, “Нарны оньс” НҮТББ-тай хамтран орон гэргүй, архины хамааралтай 120 гаруй иргэнд зөв амьдрал, Архины хор уршгийн талаар 60 минутын лекц, тоглолтоор үйлчилсэн. Театрын их засварын ажил 2025 оны 5 дугаар сараас эхлэн явагдаж байгаа бөгөөд 11 дүгээр сараас эхлэн их танхимдаа захиалгат ажлууд авч эхлээд байна. Одоогоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ажил хийгдээгүй байна. Манай байгууллага Монголын хараагүйчүүдийн холбоо, Ахиллсын гүйгчдийн холбоо, Ерөнхий боловсролын 25, 29 дүгээр сургуультай байнгын хамтын ажиллагаатай байдаг бөгөөд соёл урлагийн чиглэлээр зохиогдож байгаад ажлуудад нь хөнгөлөлттэй үнээр үйлчилж хэвшсэн. Хэрэгжилт 100%

Гүйцэтгэлийн зорилт 6.4. Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчдэд зориулсан үйлчилгээний таатай орчныг бүрдүүлж ажиллана.

Хүрэх түвшин: Сэтгэл ханамжийн хувь 100


Биелэлт: Театрын их засварын зураг төсөлд тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчдэд зориулж, үзэгчдийн танхимд тэргэнцэртэй иргэдийн орчинг төлөвлөж оруулсан, тухайн үйлчлүүлэгчдэд зориулсан театрын ариун цэврийн өрөөг шинэчлэхээр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүйн удирдамж”-ийн дагуу UCS1001A:2023, UCS1001C:2023 стандартад нийцсэн зураг төслийг хийлгэж, үзэгчдийн танхим руу орох хаалганы ойролцоо байршилд төлөвлөн тохижуулсан. Тус өрөөний хаалга автоматаар нээгдэх бөгөөд өрөөнд тэргэнцэртэй иргэний хөдөлгөөн чөлөөтэй байхаар орон зайг бүрдүүлж, шаардлагатай бүх тоноглол, төхөөрөмжийг суурилуулсан нь тусгай хэрэгцээт, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэхэд тав тухтай нөхцөл бүрдсэн. Мөн театрын гадна авто зогсоолоос үүдний өндөрлөг хэсэг рүү гарах, төв хаалга руу орох шатны хэсэг, дотор вестибулиэс үзэгчдийн танхим руу орох шатны хэсэгт тэргэнцэртэй иргэд зорчих замыг стандартын дагуу тохижуулж, таних тэмдгийг байршуулснаар хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэд үзвэр үйлчилгээ авахад таатай орчин бүрдсэн. Хэрэгжилт 100%



Гүйцэтгэлийн зорилт 6.5. Ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлж ажиллана.

Хүрэх түвшин: Сэтгэл ханамжийн хувь 100

Биелэлт: Улаанбаатар театрын веб сайтын шинэчлэлт хөгжүүлэлтийн ажлыг хийж байгаа тул театрын албан ёсны фэйсбүүк цахим хуудсаар дамжуулан ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байгаагаас гадна “Шил ажиллагаа”-ны хүрээнд байгууллагын Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаар 10, Хүний нөөцийн талаарх нээлттэй мэдээллийн ил тод байдлын талаар 8, Төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдлын талаар 10, Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод нээлттэй байлгах байдлын талаар 6, мэдээ мэдээллүүдийн холбоосыг “[Хэрэглэгчийн эрх - Astvision Starter](#)” оруулан жилийн эцсийн байдлаар холбогдох тайланг бүрэн тайлагнаж ажилласан. Хэрэгжилт 100%



Бусад ажлууд:

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/33 тоот “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах” захирамжийн дагуу Нийслэлийн Улаанбаатар театраас 2025 оны 01 дүгээр сарын 18,19-ний Бямба, Ням гаригуудад БЗД-ийн 23-р хорооны нутаг дэвсгэрт нийт 86 хүний бүрэлдэхүүнтэйгээр 11 хэсэгт хуваагдан ажилласан. Энэхүү ажлын хүрээнд нийт 2392 гаруй айл өрхөөс судалгаа авч ажилласан бөгөөд эхний өдөр 1592, хоёр дахь өдөр 800 гаруй айл өрхөөр тус тус орж судалгаа авч, зуух яндан түлш угаар мэдрэгч төхөөрөмж болон галын хорын талаарх хяналт шалгалтыг явуулж ажилласан.




2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагуудын албан хаагчид, уран бүтээлчид, соёлын ажилтнуудын дунд жил бүр зохион байгуулагддаг спортын наадам амжилттай зохион байгуулагдаж шилдгүүдээ тодруулсан билээ.

Энэ жил Сагс, Волейбол, Дартс, Теннис, Биллъяар зэрэг төрлүүдэд шилдгүүдээ тодруулсан бөгөөд Улаанбаатар театрын уран бүтээлчид, албан хаагчид эрэгтэй ширээний теннисийн төрөлд хүрэл медаль, дартсны төрөлд мөнгөн медаль, эрэгтэй

сагсан бөмбөгийн төрөлд мөнгөн медаль, волейболын төрлөөс алтан медаль тус тус хүртэж баг хамт олноороо амжилт үзүүлсэн.

Мөн 2025 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын нийтээр тэмдэглэх баярын тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 204 дүгээр тогтоолоор "Соёл, урлагийн ажилтны өдөр"-ийг жил бүрийн 9 дүгээр сарын 2 дахь долоо хоногийн ням гаригт болдог билээ. Энэхүү тэмдэглэлт өдөр нь Монгол Улсын өнцөг булан бүрт ажиллаж, амьдарч байгаа болон дэлхий даяар тархан суугаа соёл, урлагийн салбарт хүчин зүтгэж буй хүн бүрийн эзэмшсэн мэргэжил, эрхэлж буй ажлаараа бахархах, омогших, үлгэрлэн таниулах, түүчээлэн өвлүүлэх бахархалт өдөр юм. Улаанбаатар театрын хамт олон Урлагийн ажилтны баяраараа спортын олон төрлөөр өрсөлдөж багаараа 4-р байрт орсон.





2025 онд байгууллагын албан хаагчид дотоодын болон олон улсын шинж чанартай тэмцээн, уралдаанд идэвхтэй оролцож, өндөр амжилт үзүүлсэн. Үүнээс дурдвал:

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Чингис хаан одонт, Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, Хөгжмийн зохиолч Б.Шаравын нэрэмжит "Сэрсэн тал 2025" дуу хөгжмийн 3-р наадам Хэнтий аймгийн Жаргалтхаан суманд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөсөн.

Б.Шаравын 300 гаруй бүтээлээс мэргэжлийн дуулаачид болон дуулаачийн ангид суралцдаг оюутан залуус дуулж, авьяас билгээ сорин оролцсоноос "Улаанбаатар театр"-ын гоцлол дуучин А.Отгонболд 2-р байр, дуучин Х. Мөнхтүвшин 3-р байрыг эзэлсэн бол дуучин Г.Алтанхуяг, Х.Хонгор нар сүүлийн шатанд үлдэж тус тус амжилттай оролцсон. Мөн "Улаанбаатар театр"-ын концертмейстр МУСТА Г.Уугандэлгэр энэ уралдааны шилдэг концертмейстрээр шалгарлаа.

Дуучдаа мэргэжлийн уралдаанд бэлтгэн, оролцуулснаар тэдний мэргэжлийн ур чадвар дээшилж, гадаадад танигдах үүд хаалга нээгдэж байна. Тайлант хугацаанд 8 уран бүтээлчийг олон улсын болон улсын чанартай уралдаанд бэлтгэн оролцуулснаас доорх амжилтыг гаргаж ажиллалаа.

1. Дуучин МУСТА Х.Мөнхтүвшин 01-р сард ОХУ-ын Москва хотод зохион байгуулагдсан "Хиблагийн нэрэмжит" ОУ-ын дуурийн дуулаачдын уралдаанд амжилттай оролцсон.



2. 2025 оны 02 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо зохион байгуулагдсан "World Music Heritage" Олон улсын дуулах урлагийн VII уралдаанд дуучин МУСТА Б.Мөрөн Тэргүүн байр, мөн "Шилдэг Аргил хоолойт"-ноор шалгарсан.



3. "Мөнгөн мод 2024" наадмын "Шилдэг дуучин" шагналыг Улаанбаатар театрын гоцлол дуучин МУСТА А.Отгонболд хүртсэн.



4. ОХУ-ын Ардын жүжигчин К.И.Базарсадаевын нэрэмжит олон улсын залуу дуурийн дуулаачдын 7-р уралдаанд дуучин Г.Алтанхуяг 3-р байр, Х.Хонгор тусгай байр, А.Отгонболд үзэгчдийн нэрэмжит шагналын эзнээр тус тус шалгарсан.



5. Дуучин МУСТА Х.Мөнхтүвшин нь ОХУ-ын Тверь хотноо 7-р сарын 01-10-ны хооронд зохион байгуулагдсан алдарт тенор С.Я.Лемешевийн нэрэмжит ОУ-ын 4 дүгээр уралдаанд 3-р байрын шагнал хүртсэн;



6. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Чингис хаан одонт, Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, Хөгжмийн зохиолч Б.Шаравын нэрэмжит "Сэрсэн тал 2025" дуу хөгжмийн 3-р наадамд гоцлол дуучин МУСТА А.Отгонболд 2-р байр, дуучин МУСТА Х.Мөнхтүвшин 3-р байрыг эзэлсэн бол дуучин Г.Алтанхуяг, Х.Хонгор нар сүүлийн шатанд үлдэж тус тус амжилттай оролцсон.



7. Дуучин МУСТА Х.Мөнхтүвшин Казахстан улсад зохиогдсон “Бибигүл Төлегенова”-ийн нэрэмжит 13-р ОУ-ын уралдааны 1 дүгээр байрын шагнал хүртсэн;



8. Монгол улсын ардын жүжигчин, доктор, профессор Шарын Чимэдцэеэгийн нэрэмжит “Дарьганга” уртын дууны олон улсын уралдааны Гранпри шагналыг гоцлол дуучин МУСТА О.Анхчимэг, тэргүүн байрыг гоцлол дуучин МУСТА Т.Баянжаргал нар тус тус хүртсэн.




9. 2025 оны 7 дугаар сарын 16-24-ны өдрүүдэд АНУ-ын Чикаго хотноо зохион байгуулагдсан "Chicago international music competition" VIII-дахь удаагийн олон улсын уралдаан Чикаго хотын "Roosevelt University"-д болж өрдөрлөсөн. Дэлхийн 100 гаруй хөгжимчин оролцсон тус уралдааны мэргэжлийн ангилалд УЛААНБААТАР ТЕАТРЫН ЁОЧИН ХӨГЖИМЧИН У.НОМИН-ЭРДЭНЭ маань өөрийн авьяас, чадвараараа манлайлан ТЭРГҮҮН байранд шалгарсан.





10. Театрын бүжигчин П.Энхтогтох маань ОХУ-ын Улаан-Үүд хотод болсон "IV Международный хореографический фестиваль-конкурс им. Л. Сахьяновой и П. Абашеева" -д "Hardworker" бүтээлээрээ бүжиг дэглээчийн төрөлд болон контемпорари бүжгийн төрөлд 1-р байр эзэллэсэн.



Их цэвэрлэгээний ажил:

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 01/320 дугаар албан бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд, их цэвэрлэгээний ажлын удирдамжид заасан хуваарийн дагуу хуваарьт талбайд их цэвэрлэгээний ажилд 49 албан хаагч оролцож, 64 шуудай хогийг гудамж талбайгаас цэвэрлэж тушаав.



ХЯНАСАН:
ДАРГА

УЛААНБААТАР ТЕАТР
Д.АРИУНБААТАР
ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖИЛ, ТАЙЛАН МЭДЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
УЛААНБААТАР ХОТ

Д.АРИУНБААТАР

Б.ӨНӨРЦЭЦЭГ